

## **ЗҮҮН ХОЙД АЗИД “ЭНХИЙН ТОГТОЛЦОО”-Г БУЙ БОЛГОХ ЭХНИЙ АЛХАМУУД**

**Ж.Баттөр<sup>1</sup>**

### **1. Энхийн тогтолцоог бий болгох боломж**

Дэлхийн улс орнуудын хооронд “*Энхийн тогтолцоог хэрхэн тогтоох вэ?*” гэсэн асуудлаар жирийн иргэдээс авахуулаад төрийн түшээд, гүн ухаантнууд, сэтгэгчид эртнээс янагш эргэцүүлэн тунгааж, хэлэлцэн ярилцаж, ном бүтээл туурвисаар өнөөг хүрсэн билээ. Тэгсээр энэхүү амин чухал асуудлаар эсрэг тэсрэг ч гэж хэлж болох онол, үзэл баримтлалын хэд хэдэн урсгал бий болсон юм. “*Хүн төрөлхтөнд бат бэх энх тайвныг хэрхэн тогтоох вэ? Ямар арга зам, ямар үзэл баримтлал, ямар бодлогоор тогтоох вэ?*” гэсэн эрэл хайгуулууд яваандаа дэлхийн улс төрийн бодлогозүй (World Politics), олон улсын харилцааны онол ухагдахуун (International Relation’s theories), улс орнуудын гадаад бодлого (Foreign Policy)-д чухал байр суурь эзлэн, олон ном бүтээлийн сэдэв, агуулга болсон байдаг.

Дэлхий дахинд бат бэх энх тайвныг тогтоон цогцлооход шинжлэх ухааны аргачлал, философийн сэтгэлгээнд үндэслэсэн бүтээлийн тоонд Германий гүн ухаантан Иммануэл Кантын 1795 онд туурвисан “*Мөнхийн энхтайван: Гүн ухааны зураглал*” (Perpetual Peace: Philosophical Sketch) хэмээх эсээ-номыг зайлшгүй дурдах учиртай. Товч тодорхой хэрнээ гүн гүнзгий утга санаа агуулсан, хэдэн зууны тэртээ

---

1. МУИС-ийн ОУХНУС-ийн Олон Улсын Харилцааны тэнхим, дэд профессор

бичигдсэн мөртлөө өнөөгийн хүн төрөлхтний амин чухал асуудлыг нэн тодорхой илэрхийлсэн, философи, улс төр, цэрэг, нийгмийн асуудлуудыг шийдэхээр зоримог санаачилгууд дэвшүүлсэн уг бүтээлийг зарим судлаачид “Энх тайвны хөтөлбөр” гэж нэрлэсэн буй. Чухамдаа уг эсээг Энхийн гэрээний төсөл, драфт гэж хэлж болно. Хэдийгээр энэ ганц өгүүлэлд Кантын дээрх зохиолыг тайлбарлах боломжгүй ч гол санааг нь товч зангидбал дараах мэт.

Тэрбээр “Мөнхийн Энх тайван”-ыг тогтоохын тулд улс орнууд хоорондоо “Энхийн Хэлэлцээр” байгуулах ёстой, гээд дараах заалтуудыг оруулах ёстой гэсэн байдаг.<sup>1</sup> Үүнд:

1. Хэрвээ аливаа энхийн гэрээ байгуулах үед шинэ дайны үндэс нууц байдлаар хадгалагдаж байгаа бол түүнийг энхийн гэрээ гэж үзэж үл болно.<sup>2</sup>
2. Том жижиг хамаагүй ямар нэг тусгаар тогтносон улсыг аль нэгэн улс орон өв залгамжлал, солилцоо, худалдан авах, бэлэглэлээр өөрийн болгож үл болно.<sup>3</sup>
3. Бүх улсын байнгын армиудыг яваандаа бүрэн татан буулгаж, алга болгох ёстой.<sup>4</sup>
4. Улсын өр төлбөрүүдийг (бусад улсууд) гадаад улс төрийн бодлогын зорилгоор ашиглаж үл болно.<sup>5</sup>
5. Ямар ч улс орон бусад улс орны улс төрийн тогтолцоо болон засаглалд хөндлөнгөөс оролцож үл болно.<sup>6</sup>

Улмаар дараагийн хэсэгтээ доор дурдсан заалтуудыг Мөнхийн Энх тайвны Хэлэлцээрт оруулан улс орнуудын дайсагналцалыг зүгээр нэг зогсоох бус, улс төр, хууль эрхийн үндэс дээр суурилах ёстойг уриалсан буй.

1. Улс болгоны иргэний засаглал нь Бүгд найрамдах засаглалтай болох ёстой.
2. Олон улсын эрхзүй нь эрх чөлөөт орны орнуудын Холбооны үзэлд суурилах ёстой.
3. Хүн төрөлхтний иргэний эрх нь бүх нийтийн зочломтгой байдлын нөхцөлөөр хязгаарлагдах ёстой.

Одоогийн хэллэг, ойлголтоор бүх улс орнууд ардчилсан засаглалтай болох, улс орнууд НҮБ маягийн олон улсын байгууллагатай болох, бусад улс орны эрхийг заавал Олон улсын гэрээний үндсэн дээр хангах ёстой гэсэн дээрх ойлголтууд нь өнөөдөр нэлээд зүйл нь ажил хэрэг болсон.

Хэдийгээр И.Кант ийнхүү бүх дэлхийн улс орнуудын хооронд “Мөнхийн Энхийн гэрээ хэлэлцээр” байгуулах бүтээлээ 1795 онд туурвиж байсан ч дэлхий даяар энх тайвныг шинжлэх ухааны үндэслэлтэй, орчин үеийнхээ судлагааны аргазүйд тулгуурлан судлах болсон үйл явц нь саяхных, бүр тодруулбал 1950-иад оны сүүлч, 1960-аад оны эхнээс юм. Үүний голлох жишээ нь эдүгээ энх тайвны судлалын тохоохон судалгааны хүрээлэн болох ПРИО 1959 онд байгуулагдсан юм.<sup>7</sup>

## 2. Зүүн хойд Ази дахь энхийн гэрээнүүд

Өнөөгийн даян дэлхийн хэмжээнд, улс орнуудын хооронд өрнөж буй хамгийн том үйл явцыг судлаачид “Даяаршил, Интеграцчилал, Бүс нутагшил” гэж нэрлэж байгаа юм. Зарим судлаачид эдгээр үйл явцыг “Олон агуулгатай, олон аспекттэй, амьдралын болоод харилцааны” бүх талыг улам бүр хамарч байгааг цохон тэмдэглэсэн буй.<sup>8</sup> Зүүн хойд Азийн улс орнуудын цаашдын “Алсын Хараа” (Vision) нь юу байж болох вэ? Манай бүс нутагт үнэхээр бат бэх энх тайван, хөгжил цэцэглэлт, итгэлцэлийг бий болгоё гэвэл бидэнд Европын Холбоо шиг юм уу, бүр тийм байж чаддаггүй юм аа гэхэд АСЕАН шиг Холбоо, Хэлэлцээр хэрэгтэй байгаа юм.

Хэдийгээр нэлээд асуудлууд байдаг ч Зүүн хойд Азийн улс орнуудын хооронд энх тайван өөд тэмүүлсэн баталгаажуулсан, хамтын ажиллагаанд чиглэсэн хэлэлцээрүүд байдаг. Наад зах нь Зүүн хойд Азийн улс орнуудын таван тулгуур багана гэж хэлж болохуйц гэрээ хэлэлцээрүүд бий.

Эхний багана нь АНУ-Японы хооронд байгуулсан 1952 оны Сан Францискогийн Энхийн Хэлэлцээр (San Francisco Peace Treaty) юм. Энэхүү Энхийн хэлэлцээр-г суурилан АНУ-Японы Харилцан батлан хамгаалах хэлэлцээрийг (Mutual Defense Treaty)-г үзэглэсэн агаад Японыг цэрэг армигүй болгож, Японы гадаад бодлого нь АНУ-д чиглэж төвлөрсөн байдаг. Япон ч “Энх тайванч Үндсэн хууль” баталж,

уг Хуулиндаа 9-р бүлгийг оруулсан. Энх тайванч Үндсэн хуулийнхаа агуулгаар Япон улсын баглан хамгаалахын зардал нь ДНБ-ний 1 хувиар хязгаарлаж, зөвхөн Өөрийгөө хамгаалах Хүчин (Self-defense Forces)-тэй байх ба гадаадад цэрэг дайчид илгээхгүй болсон.

Хоёрдахь багана нь 1972 оны Америк-Хятадын хооронд байгуулсан 1972 оны Шанхайн коммуникую (Shanghai Communiqué) юм. Уг баримт бичигт дурдахдаа АНУ-ын Ерөнхийлөгч Ричард Никсон Хятадын төрийн тэргүүн Мао Зедун нар Америк, Хятад хоёр орон “Ази-Номхон далайн бүс нутагт “жанжлах үзэл” баримтлахгүй, гаргахгүй” гэдэг дээр харилцан зөвшөөрсөн.

Гуравдахь багана нь 1972 оны Хятад-Японы Хамтарсан Мэдэгдэл (Sino-Japanese Joint Declaration) юм. Энэхүү Хамтарсан мэдэгдэлд бичсэнээр “Хятад улс АНУ-Японы цэргийн Холбоотнууд гэдгийг нь албан ёсоор хүлээн зөвшөөрөхөө мэдэгдэж, хариуд нь Япон улс БНХАУ бол Хятадын ард түмний цорын ганц хууль ёсны засаг төр, Засгийн газар (the sole legitimate government) мөн” гэсэн. Түүнчлэн Хятад улс Японоос дайны нөхөн төлбөр (reparation) шаардахгүй гэсэн баталгаа гаргаж, хариуд нь Япон улс Хятадтай эдийн засгийн салбарт ихээхэн идэвхитэй хамтран ажиллана, хөрөнгө оруулалт хийнэ гэсэн. 2000 он гаргал дээрх хоёр улс хэлсэндээ хүрцгээж хамтын ажиллагаа нь үнэхээр цэцэглэсэн байдаг. Бас нэг амлалт нь харилцан газар нутгийн маргаан гаргахгүй гээд иймэрхүү асуудлыг “хойш тавьсан” болой.

Дөрөвдэх багана нь 1965 онд БНСУ-Япон улс хоёр талын харилцаагаа хэвийн болгосон явдал байсан юм. 1910 онд Солонгос орон Японы колони улс болсон агаад дэлхийн 2-р дайн дуусахад Япон Солонгосын Хойгоос гарч явснаар энэ колончлол нь дуусгавар болсон юм. 1948 онд БНСУ байгуулагдсаныг тунхагласан ч 1950-1953 онд Солонгосын дайн өрнөн Солонгос улс хоёр хуваагдсан. Тиймээс 1965 оны уг Гэрээ ихээхэн ач холбогдолтой баримт бичиг байв. Учир нь дээрх нь Гэрээгээр Япон улс Өмнөд Солонгосыг (БНСУ-ыг) Солонгосын нийт ард түмнийг төлөөлсөн цорын ганц хууль ёсны Засаг төр хэмээн хүлээн зөвшөөрч, 1910 онд Солонгосыг хүчээр өөртөө нэгтгэсэн гэрээнүүдийг хүчингүй болгосон төдийгүй, колоний засаглал, ноёрхолынхоо төлөө БНСУ-ын засаг төрд нөхөн төлбөр (compensation) төлөхөө зөвшөөрсөн.<sup>9</sup>

Гэхдээ 2010-аад оноос эхлэн АНУ болон Хятад, Япон-Хятадын хооронд маргаан зөрчил хурцадсан бөгөөд Япон Солонгосын хооронд ч арал, түүх зэрэг маргаан тасрахгүй байгаа юм. Сонирхолтой нь дээрх орнуудын хооронд Энхийн, Эвлэрэлийн Гэрээ хэлэлцээр байгуулагдаж байх үед буюу 1960, 1970-аад онд ЗХУ, БНХАУ-ын харилцаа муудан муудсаар бүр дайн мөргөлдөөн гарах хэмжээнд хүрээд байсан ч эдүгээ харилцаа нь хамгийн их ойртон нягтарч буй орнууд болжээ.

Тэгвэл тавдахь баганаар ямар гэрээ, хэлэлцээрийг нэрлэж болох вэ?

Судлаач миний дүгнэлтээр Орос Хятадын 2001 оны “Сайн хөрш, найрамдал, хамтын ажиллагааны Гэрээ” (“Договор о добрососедстве, дружбе и сотрудничестве”) болов уу гэж бодож байна. Энэ Гэрээг үзэглэхийн төлөө ОХУ, БНХАУ-ын холбогдох мэргэжилтнүүд арван жил хөдөлмөрлөсөн агаад үр дүнд нь ч хоёр орны талаас стратегийн хамтын ажиллагаагаа хөгжүүлэх бат бэх бааз сууриа тавьсан юм. Гэхдээ зарим судлаачдын дүгнэснээр хоёр орны хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтын хэмжээг эрс нэмэгдэхэд хүргэж байгаа ч нөгөө талаар дээрх хоёр орны харилцааг Цэрэг-улс төрийн Холбоотон (Военно-политический Союз) маягтай болсон гэдэг.

### 3. Монгол улс Зүүн Хойд Азийн Энхий тогтолцоог мөрөөдөж байна.

#### **Зүүн хойд Ази дахь Монгол улсын онцлог**

Юуны түрүүнд, Монгол орон дэлхийн гурван том соёл иргэншлийн голд оршдоогоороо өвөрмөц онцлогтой гэж хэлж болно.<sup>10</sup> Энэ нь хойгуураа Христосын Ортодокс-Үнэн алдартны шашин бүхий оростой, Өмнүүрээ Зүүн Азийн гол үзэл баримтлал болж Күнзийн сургааль бүхий Хятадтай, баруунаараа исламын шашинт Казахстан, Хятадын Шинжаан уйгартай хиллэж байна. Монголын Баян өлгий аймгийн хүн амын дийлэнх нь ислам шашин шүтдэг.

Олон улсын харилцааны шинжлэн ухаанд улс орнуудыг Хүчин чадал (Power)-аар нь

- Бага буюу жижиг улс (Small Power)
- Дунд зэрэглэлийн улс (Middle Power)
- Том буюу их гүрэн (Big Power)

- Бүс нутгийн их гүрэн (Regional Power)
- Дэлхийн хэт их гүрэн (Super Power or World Power) гэж ангилдаг.

Бага жижиг улс гэдэгт олон улсын харилцааг шууд тодорхойлж байгаа их гүрнүүдийн бодлогод шууд нөлөө үзүүлж чаддаггүй улсыг үндсэнд нь ойлгодог байна. Монгол улс энэ бүс нутагт ерөнхийдөө жижиг буурай гэсэн ангилалд орно. Монгол улсын жижиг буурай байдал, энэ онцлог нь гадаад бодлого, нийгэм эдийн засгийн хөгжилд нөлөөлж буй талаар тусгайлан анализ хийх ёстой учир үүгээр товчилъё.

Монгол улс мөн бүс нутагтаа жийргэвч улс гэсэн байрлалтай. Жийрэг улс ихэвчлэн жижиг байдаг бөгөөд хоёр том гүрний хооронд хавчигдсан байдаг онцлогтой аж.<sup>11</sup>

Монгол улс Зүүн хойд Ази дахь далайд гарцгүй ганц орон юм. Далайд гарцгүй байх нь нийгэм эдийн засаг улмаар улс төрд ч ихээхэн саад тотгор болдгийг судлаачид тэмдэглэсэн байдаг.<sup>12</sup>

Зүүн Хойд Азийн орнуудаас Монгол улсын баримталдаг эрс ялгаатай онцлог шинж нь олон улсын түвшинд албан ёсоор “цөмийн зэвсэггүй орон” гэсэн статус авсан байдал нь болно. Харилцан үл итгэлцэл байдгаас Зүүн хойд Азийн орнууд цөмийн зэвсгийн бодлоготой. (ОХУ, АНУ, БНХАУ цөмийн асар их тооны зэвсэгтэй, Хойд Солонгос цөмийн туршилт удаар дараа үйлдэж, цөмийн зэвсэг бүтээхээр чармайдаг, Япон, Өмнөд Солонгос нь АНУ-ын цөмийн шүхэр дор байдаг.)

Тиймээс Монголчууд газар нутаг, аюулгүй байдлаа тун өвөрмөц байдлаар хамгаалдаг гэж хэлж болно. Тэр нь олон улсын хамтын нийгэмлэг ялангуяа НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн таван орноор аюулгүй байдалдаа бичгээр баталгаа гаргуулсан явдал юм. Ингээд 1990 оноос эхлэн нухацтай судалсаар 1992 онд НҮБ-ын 47-р Чуулганы хуралдаан дээр Монгол улс нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс болгож буйгаа тунхагласан. Үүнээс хойш 20 жил маш их хүчин зүтгэл гаргасаар 2012 оны 9-р сарын 12-нд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн Байнгын таван гишүүн орноор баталгаа гаргуулсан юм. Үүний дундуур буюу 1998 оны 12 сарын 4-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 53/77 Д тоот тогтоолоор дээрх таван гүрэн Монгол улсын Аюулгүй байдалд баталгаа гаргаж өгсөн.<sup>13</sup> Эдгээр нь өнөөдөр Монгол улсын аюулгүй байдлын олон улсын эрхзүйн гол баримт бичиг мөн.<sup>14</sup>

### **Зүүн Хойд Азийн энх тайвны төлөөх Монгол улсын санаачилгууд**

Зүүн хойд Азид бат бэх энхийн тогтолцоог бий болгохын төлөө Монгол улс олон жил идэвх санаачилгатай ажиллаж байгаа юм. Монголын Засгийн газраас Ази тивийн улс орнуудад хандан тус тивд энх тайвныг тогтолцоо чухал болохыг илэрхийлэн, дайн түүний дотор цөмийн дайн гаргуулахгүй байхын төлөө хамтран ажиллахыг уриалсан анхны санаачилгыг 1981 онд гаргасан байдаг. Уг санаачилгаа Ази, Номхон далайн бүх орны парламентад хандан мэдэгдсэн агаад 1981-1983 онуудад Азийн 36 орон, Номхон далайн 11 орон, бусад орныг оролцуулаад нийт 50 орны төр, засгийн тэргүүнд илгээлт явуулсан агаад 19 орон Монгол улсын бодлогыг дэмжин хариу ирүүлсэн байдаг.<sup>15</sup>

Улмаар 1986 онд бүс нутгийн энх тайван, хамтын ажиллагааг хөгжүүлэх, цөмийн дайнаас сэргийлэх нийт Азийн Чуулга уулзалт зохион байгуулъя гэсэн санаачилга гаргасан юм. Хэдийгээр тухайн үеийн Ази дахь сөргөлдөөнт байдлаас шалтгаалаад энэ санаачилга хэрэгжээгүй ч АНУ, БНХАУ, Япон гэх мэт бүс нутгийн голлох орнууд Монголд анхаарлаа хандуулах болсон юм. Яваандаа Ази Номхон далай гэсэн том бүсэд нөлөөлөх амаргүй нь харагдсан тул Зүүн Хойд Ази гэсэн Монгол улс өөрийнхөө оршиж буй бүс нутаг руугаа хандсан дипломат ажиллагаа идэвхитэй өрнүүлэх болсон билээ. Ингэхдээ тэр үед Зүүн Хойд Ази гэхгүй, Ази Номхон далайн орнуудын Зүүн хойд хэсгийн орнууд гэсэн нэр томъёог гаргаж ирсэн юм. Энэ нэршил 1989 онд Монголын гадаад бодлогод томоохон өөрчлөлт орж эхлэсний дохио болж эхлэсэн.

1989 онд Монгол улс Халх голын дайны 50 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн юм. Энэ ялалтын ойд зориулсан хурал дээр Монголын Засгийн газраас Ази Номхон далайн зүүн хойд хэсгийн орнуудын хооронд байнга үйлчлэх яриа хэлэлцээний механизм бий болгож дайн түүний дотор цөмийн дайнаас хамтын хүчээр сэргийлье, хамтран хөгжин цэцэглэе гэсэн санаачилга гаргасан билээ. Уг санаачилга, гадаад бодлогоо бүс нутгийн орнууд түүний дотор Хойд Солонгосын талд шургуу танилцуулж ойлгуулахаар чармайж байв. Монголын Засгийн газраас дэвшүүлсэн дээрх улс төр, гадаа бодлогын санаачилгууд, тэдгээртэй уялдуулан явуулсан өргөн цар хүрээтэй дипломат ажиллагаа нь Зүүн хойд Азид Монгол улс өөрийн байр сууриа

бэхжүүлэхэд ихээхэн түлхэц болсон юм. Үүнийг дотоод гадаадын эрдэмтэд ч цохон тэмдэглэсэн байдаг. Тухайлбал, Германы судлаач Удо Б. Баркманн: ...Гадаад бодлогын хувьд бий болсон энэхүү шинэ нөхцөл байдал бие даасан үйл ажиллагаа явуулах орон зай, боломжоор хангаж өглөө. АНУ Монгол улстай дипломат харилцаа тогтоож, Монгол улс Японтой харилцаагаа идэвхжүүлэн, өмнөд хөрш Хятад улстай ч найрсаг харилцаагаа эргээн сэргээв. Гадаад харилцаагаа ийнхүү өргөжүүлснээр Монгол улс дотоодын эдийн засгийн асуудлуудаар шинэ түншүүдтэйгээ харилцан хэлэлцэж, өөрийн хөгжлийн онцлогийг тэдэнд таниулах боломж нээгдэв.<sup>16</sup>

### Шинэ зуунд

Эдгээр санаачилгууд, оролдлого зүтгэлийн үр дүнд Монгол улс бүс нутгийнхаа бүх оронтой найрсаг, үр бүтээлтэй харилцаа тогтоож, бодитой хамтын ажиллагаагаа хөгжүүлж байна. Монгол улс Зүүн хойд Азид энх тайвныг тогтооход өөрийн хувь нэмрийг оруулахын төлөө одоо ч чармайлт гаргасаар буйн илрэл нь “Улаанбаатарын яриа хэлэлцээ” хэмээх санаачилга юм. Энэхүү санаачилгыг Монгол улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Ардчилсан орнуудын Хамтын нийгэмлэгийн Сайд нарын VII хурлын үеэр буюу 2013 оны 4-р сард дэвшүүлсэн юм. Уг санаачилгын албан ёсны нэршил нь “ЗХА-ийн Аюулгүй байдлын асуудлаарх Улаанбаатарын яриа хэлэлцээ” болно.

Улаанбаатарын яриа хэлэлцээний гол аженда нь:

- Хойд Солонгосыг цөмийн зэвсэгээс ангижруулахад хувь нэмрээ оруулах,
- бүс нутгийн яриа хэлэлцээ, уулзалтад татан оролцуулах,
- бүс нутгийн итгэлцлийг бэхжүүлэхэд оршиж байна.

Өнгөрсөн хугацаанд Монгол улсын ГХЯ-наас “Улаанбаатарын яриа хэлэлцээ” санаачилгын талаар Меморандум гаргасан бөгөөд өнгөрсөн 2014 оны 6-р сард эрдэмтэн, судлаачидын дунд олон улсын эрдэм шинжилгээний бага хурал амжилттай зохион байгуулсан юм. Тус эрдэм шинжилгээний хурлыг жил бүр хийхээр төлөвлөсөн.

Уг бага хуралд БНСУ, БНАСАУ, АНУ, Хятад, Орос, Япон болон Европын зарим орны төлөөлөгчид оролцсон. Улаанбаатарын яриа хэлэлцээ нь зөвлөлдөх механизмийн хувьд бодлого боловсруулагчид, НҮБ-ын Ази Номхон далайн Эдийн засаг, Нийгмийн Хороо (United Nations Economic and Social Commission for Asia and the Pacific буюу ESCAP) зэрэг олон улсын байгууллагууд болон иргэний нийгмийн байгууллагуудыг нэгэн дор цуглуулан, эдийн засгийн хамтын ажиллагаа, цэрэг батлах хамгаалах салбарын ил тод байдал, байгаль орчны асуудлууд, аюулгүй байдлын уламжлалт бус аюул заналууд, бүс нутгийн тогтвортой байдал, соёл боловсролын солилцоо, харилцааны талаар бүс нутгийн төлөөллийг оролцуулан хамтран ажиллах боломж бололцоог буй болгоход оршиж байгаа юм.<sup>17</sup> Түүнчлэн Монгол улсын Ерөнхийлөгч Хойд Солонгост айлчлах хугацаандаа 2013 оны 11 сарын 1-нд Ким Ир Сэний их сургуульд дээр уншсан лекц нь Зүүн хойд Ази, Хойд Солонгосын талаарх бодлогыг тодорхойлсон төдийгүй бүс нутгийн орнуудын анхаарлыг ихээр татсаныг тэмдэглэх хэрэгтэй.

### **Монгол улсын бүс нутагтаа буй болгосон давуу талууд**

Зүүн хойд Ази бол бүс нутгийн аюулгүй байдлын баталгааны механизм буюу энх тайвны тогтолцоо нь сул бөгөөд Монголоос бусад бүх орон цэрэг, улс төрийн ихээхэн амбицтай, Хойд Солонгосоос бусад нь эдийн засгийн өсөлт өндөр улсууд билээ. Мөн өвөр хоорондоо нэлээд ноцтой хэмжээнд маргаан, дайсагнал, зөрчилтэй улсууд гэдгийг бид мэднэ. Тэдгээр зөрчилтэй асуудлууд гэхэд

- Газар нутаг, арлын маргаан, хилийн зурвас (Хятад Япон, Орос-Япон, Өмнөд Солонгос-Япон, Хятад –Өмнөд Солонгос, Өмнөд-Хойд Солонгос NLL)
- Түүхийн маргаан (Япон Солонгос, Хятад-Япон, Хойд Солонгос-АНУ, Хойд-Өмнөд Солонгос)
- Гэтэл Монголын давуу тал нь:
- Дээрх орнуудаас аль ч оронтой нь газар нутаг, хилийн шугамын маргаангүй.

- Өнгөрсөн түүхээс (ялангуяа нэн шинэ түүхээс) улбаатай хэрүүл маргаан байхгүй. Бүс нутгийн бүх улс оронтой түүхийн хамтарсан судалгаа хийж, археологийн чиглэлээр нягт хамтран ажилладаг.

Эдгээрээс гадна, Зүүн Хойд Азийн бүх улс оронтой улс төр, эдийн засгийн интегралчлалын бүхий л талаар бэхжүүлэхээр чармайн ажилласны үр дүнд хамтын ажиллагааны ихээхэн ололт амжилтанд хүрээд байна. Тухайлбал,

- Японтой Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулсан.
- ОХУ-тай “Стратегийн Иж бүрэн Түншлэлийн Гэрээ” байгуулсан.
- БНХАУ-тай “Стратегийн Иж бүрэн Түншлэлийн Гэрээ” байгуулсан.
- АНУ-тай 2004 онд “Худалдаа хөрөнгө оруулалтын Ерөнхий хэлэлцээр”, 2013 онд “Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай Монгол улс, АНУ хоорондын хэлэлцээр”-т 2013 онд байгуулсан. Мөн 2014 онд “Монгол улс, АНУ-ын Аюулгүй байдлын асуудлаарх хамтарсан мэдэгдэл”-д хоёр орны Батлан хамгаалахын сайд нар гарын үсэг зурсан.
- БНСУ-тай “Иж бүрэн Түншлэлийн Гэрээ” байгуулсан.
- БНАСАУ-тай 2002 онд “Найрсаг хамтын ажиллагааны тухай Гэрээ” байгуулсан.

**НОМЗҮЙ**

1. “К вечному миру” И Канта. Подготовка текста, вступительная статья и заключение А. В. Гулыги. Московский Рабочий, 1989.
2. Мөн ном. стр. 24.
3. Стр.24.
4. Стр. 25.
5. Стр. 26.
6. Стр. 27.
7. Прио (PRIO) нь “Peace Research Institute Oslo” буюу “Ослогийн Энх тайваны Хүрээлэн” гэдэг үгийн товчлол юм. Энх тайван хэрхэн тогтоох, зөрчил мөргөлдөөнийг энхийн арга замаар шийдвэрлэх талаар судалгаа хийдэг уг хүрээлэнг Норвегийн Засгийн газар, Европын Комисс болон бусад олон улсын байгууллагууд санхүүжүүлдэг.
8. В. Балакин “Европейский опыт региональной интеграции для Восточной Азии”, *Проблемы Дальнего Востока*, 4/2012. стр. 119-120.
9. US-China and China –Japan Clashes, *Chosun Daily* (9 January 2014), Euikon Kim (Inha University) “Rising China and Turbulent East Asia: Asianization of China?” *Pacific Focus*, Inha Journal of International Studies, Volume XXIX No.1, April 2014. pp. 3-4.
10. Л. Хайсандай. “Монгол улсын хөгжлийн бодлого ба Зүүн хойд Азийн үүрэг холбогдол”, Стратеги судлал сэтгүүл, No. 45 (1/2009), 133-р тал.
11. О. Машбат, “Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал ба Гуравдагч хөршийн бодлогын хязгаар”, *Стратеги судлал сэтгүүл*, No.56 (4/2011), 29-тал.
12. Paul Collier, “The Bottom Billion: Why Poorest Countries Failing and What Can Be Done About It”. Oxford University Press. 2008.
13. “Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчины судалгаа, дүн шинжилгээ”. УБ. 2014, 75-80-р тал.

14. J. Enkhsaikhan, “Mongolia’s Nuclear-Weapon-Free Status: Concepts and Practice,” *Asian Survey*, Vol.40, No.2 (Mar.,-Apr., 2000), pp. 342-359.
15. “Монголын гадаад харилцаа: Он дарааллын бичиг”, НЭПКО паблишинг, 2014, 190 дэх тал.
16. Удо Б. Баркманн. Монголын түүх, улс төрийн асуудлын тухай өгүүллүүд. МУИС, УБ. 2013, 141 дэх тал. Монгол хэлээр.
17. David L. Caprara, Katharine H.S. Moon and Paul Park, “Mongolia: Potential Mediator between the Koreas and Proponent of Peace in Northeast Asia”. <http://www.brookings.edu/research/opinions/2015/01/20-mongolia-north-korea-caprara-moon-park>
18. *The Korea Herald*, 2013.11.15